



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “БОР-ӨНДӨР”
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 30 өдөр

Дугаар A/16

Бор-Өндөр сум

Хөрөнгө актлах тухай

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус сургуулийн 35110 тоот данснаас 6 нэр төрлийн 88 ширхэг 2,750,000 (хоёр сая долоон зуун тавин мянга) төгрөгийн эд хөрөнгийг 1 дүгээр хавсралтаар, 35410 тоот данснаас 328 ширхэг 1,921,000 (сая есөн зуун хорин нэгэн мянга) төгрөгийг 1 дүгээр хавсралтаар, 34420 тоот данснаас 55 нэр төрлийн 236 ширхэг 9,459,700 (есөн сая дөрвөн зуун тавин есөн мянга долоон зуун) хавсралтаар тус тус хөрөнгийг актлаж , хасахыг зөвшөөрсүгэй.

2. Актлах хөрөнгийг сургуулийн өмч хамгаалах зөвлөлийн хяналтан доорх устгахыг нярав (Ж.Жавхлан), нягтлан Б.Анхчимэг нарт даалгасугай.

ЗАХИРАЛ

Ц.ГАНХҮҮ

